



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН
ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.04.12

№

14

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т тус тус заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

1.2008 онд Монгол Улсын Засгийн газрын гаргасан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 153 дугаар тогтоолоос эхлэн Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн хороо болон бусад холбогдох газрын гаргасан тогтоол шийдвэр, байгуулсан гэрээ хэлэлцээрийн талаар;

2.2012 онд Төрийн өмчийн хорооноос Эдийн Засаг, Хөгжлийн яаманд хандан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгааг үндэслэн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”-ийн менежментийг “Кью Эс Си” ХХК-д шилжүүлсэн тухай, улмаар менежментийн гэрээг концессын гэрээ болгон өөрчлөх тухай асуудлыг удаа дараа тавьж байсан талаар;

3.2012 онд Эдийн Засгийн Хөгжлийн сайд Н.Батбаяр “Кью Эс Си” ХХК-тай байгуулсан “Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх” тухай /Шинэчлэн сайжруулах–барих–ашиглах–шилжүүлэх, барих–шилжүүлэх/ концессын гэрээний талаар;

4.Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 2013 оны тогтоолд 2015 онд оруулсан өөрчлөлтийн талаар;

5.2015 оны Засгийн газрын 364 дүгээр тогтоолд заагдсан “Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах” концессын төсөл хэрхэн хэрэгжиж байгаа болон цаашид ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа талаар;

6.“Кью Эс Си” ХХК менежментийн гэрээний дагуу “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨҮГ-т хөрөнгө оруулсан эсэхийг шалгасан Үндэсний Аудитын газрын дүгнэлт, тус компанид Хөгжлийн банкнаас олгосон зээлийн талаар зэрэг болно.

Асуулгатай холбоотой доорх мэдээллүүдийг дэлгэрэнгүй ирүүлнэ үү.

1.2008 онд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай гаргасан Засгийн газрын 153 дугаар тогтоолын талаар;

2022000027

2.2010 онд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨҮГ, “Кью Эс Си” ХХК-ийн хооронд байгуулсан “Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх” тухай хөрөнгө оруулалтын гэрээний талаар;

3.2011 онд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨҮГ, “Кью Эс Си” ХХК-ийн хооронд байгуулсан “Дэд бүтэц байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх” тухай хөрөнгө оруулалтын гэрээний талаар;

4.2012 оны Төрийн өмчийн хорооны 326 дугаар тогтоолын талаар;

5.2012 оны “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 327 дугаар тогтоолын талаар;

6.2013 оны Үндэсний Аудитын газрын 2010-2012 оны хооронд 81.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн тухай дүгнэлтийн талаар;

7.2013 оны Төрийн өмчийн хорооны концессын гэрээ болгон өөрчлөх тухай 471 дүгээр тогтоолын талаар;

8.2013 оны Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 317 дугаар тогтоолын талаар;

9.2014 оны Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын 69 дүгээр тогтоолын талаар;


10.2014 оны ЭЗХЯ, “Кью Эс Си” ХХК-ийн хооронд байгуулсан “Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ”-ний талаар;

11.2014 оны Хөгжлийн банкнаас “Кью Эс Си” ХХК-д олгосон 71.3 сая долларын зээлийн талаар;

12.2015 оны Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 364 дүгээр тогтоолын талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Н.АЛТАНХУЯГ

2022000027